



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/92

Улаанбаатар хот

Мэдүүлгийн загварт нэмэлт оруулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм"-ийн "Гурав" дахь хэсгийн 15-ын "а", 16-гийн "к" заалт, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны А/57 дугаар тушаалаар баталсан "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам", "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2014 оны А/63 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2014 оны А/63 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах өргөдөл гаргагчийн мэдүүлэг"-ийн 2-т "БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1989 оны 198, 199 дүгээр зарлигын дагуу тэтгэврийн насанд хүрээгүй хүрээгүй байхдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэн". 3-т буй хүснэгтийн "1991" оны дээд хэсэгт "1990 оны 7-12 сар" гэсэн нэмэлт өөрчлөлтийг тус тус оруулсугай.

2. Энэхүү тушаалын дагуу холбогдох програм хангамжид 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн дотор өөрчлөлт хийж, хэрэгжүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар)-д даалгасугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (Д.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.УРТНАСАН

**АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТООЦУУЛАХ
ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛЭГ**

Мэдүүлгийн дугаар		Тэтгэврийн дэвтрийн дугаар	
-------------------	--	----------------------------	--

Он Сар өдөр

1. ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН:

Овог _____ Эцэг (эх)-ийн нэр _____ Өөрийн нэр _____

Регистрийн дугаар:

ХОЛБОО БАРИХ ХАЯГ, УТАСНЫ ДУГААР:

2. ӨРГӨДӨЛ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ: (ТОХИРОХ ЗААЛТЫГ СОНГОН ✓ ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙНЭ)

- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөж хүмүүжүүлсэн эхчүүд 15-аас доошгүй жил ажиллаж 50 насанд хүрсэн, эсхүл 20-иос доошгүй жил ажиллаж нас харгалзахгүйгээр;
- Нийтдээ 32-оос дээш жил ажиллаж, 55 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;
- 27-гоос дээш жил ажиллаж нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд;
- Нийтдээ 20-иос доошгүй жил, түүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор болон хортой, халуун нөхцөлд ажиллаж, 45 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;
- 15-аас доошгүй жил, түүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар хортой, халуун нөхцөлд ажиллаж, 40 нас хүрсэн нөхцөлөөр эмэгтэйчүүд;
- 25-аас доошгүй жил, түүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, 50 нас хүрсэн нөхцөлөөр эрэгтэйчүүд;
- 20-иос доошгүй жил, түүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, 45 нас хүрсэн нөхцөлөөр эмэгтэйчүүд.
- БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1989 оны 198, 199 дүгээр зарлигын дагуу тэтгэврийн насанд хүрээгүй хүрээгүй байхдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэн.

3. АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ НӨХӨН ТООЦУУЛАХ ХУГАЦАА: (ТОХИРОХ САРЫГ СОНГОН ✓ ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙНЭ)

Он	Сарууд												Нийт	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1990	1-6 сард нөхөн төлөлт хийгдэхгүй													
1991														
1992														
1993														
1994														
1995														
1996														
1997	1997 оны 2 ба түүнээс хойш сард нөхөн төлөлт хийгдэхгүй													
Бүгд	(.....жил.....сар, төлсөн шимтгэлтөгрөг)													

Дээрх хугацаанд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцож өгнө үү.
Өргөдөл гаргагч би нөхөн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж барагдуулахаа нотолж байна.

Гарын үсэг: _____
(Доорхи хэсгийг тасалж, мэдүүлэг гаргагчид өгнө)

Өргөдөл хүлээн авсан: _____ аймаг (дүүрэг)-ийн

Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан: _____ /

Өргөдөл хүлээн авсан огноо: _____ он _____ сар _____ өдөр.

Мэдүүлгийн дугаар	
-------------------	--